



**НЭВТРЭХ, ГАРАХЫГ ХЯНАХ ХААЛТЫН ТӨХӨӨРӨМЖ  
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛЫН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **Нэвтрэх, гарахыг хянах хаалтын төхөөрөмж нийлүүлэх**  
Төслийн дугаар: **ЭМДЕГ/202002024**

Улаанбаатар  
2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Нэвтрэх, гарахыг хянах хаалтын төхөөрөмж” нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 11 цаг 00 минут**-аас өмнө Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 11 цаг 30 минут**-д нээнэ.

Тендер хүлээн авах этгээд: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж **50.000** /тавин мянга/ төгрөгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)–ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө,  
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын байр, 205 тоот,  
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар,  
Утас: 70101107**

[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

[www.emd.gov.mn](http://www.emd.gov.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах  
эрх олгох тухай  
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<p align="center"><b>ТООЗ-ны холбогдох заалт</b></p>	<p align="center"><b>Шалгуур үзүүлэлт</b></p>
<p align="center"><b>ТООЗ 1.1</b></p>	<p><b>Тендерт оролцогчдын эрх бүхий болон гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлоход дараах материалыг ирүүлэх шаардлагатай. Үүнд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.</li> <li>2. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж ирүүлнэ.</li> <li>3. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг үнийн саналын баримт бичигт ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ. Тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</li> <li>4. Харьяа Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>5. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: <b>Шаардлагатай</b> <b>Тухайн хуулийн этгээдийн байнгын үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн шүүхийн тодорхойлолтыг ирүүлэх /иргэн болон захиргааны хэргийн шүүх/.</b> <i>Энэхүү тодорхойлолтод Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын талаар тусгасан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ.</i></li> <li>6. Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээс ирүүлнэ.</li> <li>7. Сүүлийн 2 жилийн /2018, 2019 он/ <b>аль нэг жилийн</b> борлуулалтын орлогын хэмжээ нь санал болгосон үнийн дүнгийн <b>50 хувь</b> хувиас багагүй байх.</li> </ol>
<p align="center"><b>ТООЗ 2.1</b></p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (<b>pdf</b>)-ээр илгээнэ.</p> <p>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж <b>50,000</b> /тавин мянга/ төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.</p> <p>Огноо: <b>2020 оны 5 дугаар сарын 29-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 00 минут</b></p>

<p><b>ТӨӨЗ 2.2</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:          Байшин, гудамжны нэр: <b>Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө</b>  <b>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар</b>          Давхар болон өрөөний дугаар: <b>7-р давхар, Хурлын танхим</b>          Аймаг, хот: <b>Улаанбаатар хот</b></p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:          Огноо: <b>2020 оны 5 дугаар сарын 29-ний өдөр</b>          Цаг: <b>11 цаг 30 минут</b></p>
<p><b>ТӨӨЗ 3.1</b></p>	<p><b>Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үнийн саналыг маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>2. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>3. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он /Санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сангаас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас шаардлагатай мэдээллийг шалгана/</b>. Аудитын дүгнэлтийг нотариатаар баталгаажуулж ирүүлсэн байх шаардлагатай.</li> <li>4. Сүүлийн 2 жилийн /2018, 2019 он/ аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн <b>50</b> хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг нийлүүлсэн байх. /Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ/.</li> </ol> <p>Ижил төстэй ажилд <b>“Нэвтрэх, гарах төхөөрөмж”</b> нийлүүлж, суурилуулсан туршлагыг тооцно.</p> <ol style="list-style-type: none"> <li>5. Нийлүүлэх барааны зураг, үйлдвэрлэгчийн каталоги ирүүлнэ, (Каталоги дээрээс санал болгож буй барааг ялган тодруулж ирүүлнэ.)</li> <li>6. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл эсвэл гэрээт борлуулагчийн итгэмжлэлийг ирүүлнэ.</li> <li>7. Тендерт оролцогч тухайн барааг нийлүүлэхэд тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагагүй.</li> <li>8. Нийлүүлэх барааны баталгаат хугацаа нь 12 сар ба түүнээс дээш байх ба баталгаанд хугацаанд гарсан үйлдвэрийн эвдрэл гэмтлийг өөрийн зардлаар, шуурхай засварлахыг нотолсон албан бичиг ирүүлнэ.</li> </ol> <p>Баримт бичгүүд нь Монгол хэлнээс бусад хэл дээр байгаа тохиолдолд баталгаат орчуулгын товчоогоор орчуулга хийлгэн тухай бүрт хавсарган ирүүлнэ.          Дээр заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<p><b>ТӨӨЗ 4.1</b></p>	<p>Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>тохируулахгүй тогтмол байна.</b></p>

<p><b>ТӨӨЗ 5.1</b></p>	<p>Барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт: <b>Шаардлагатай.</b></p> <p>Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдлийг баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтоос зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p>
<p><b>ТӨӨЗ 6.1</b></p>	<p>Тендер нээснээс хойш <b>30</b> хоногийн туршид хүчинтэй байна.</p>
<p><b>ТӨӨЗ 7.1</b></p>	<p>Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь <b>СІР</b> үнэ байна. Энэ үнэнд <b>даатгал, татвар, сургалт, суурилуулалт</b> болон <b>эцсийн цэг хүртэлх бусад бүх зардлууд</b> багтсан байна.</p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Нэвтрэх, гарахыг хянах, бүртгэх төхөөрөмж /хаалтны иж бүрдэл/
2. **Бүрдэл:** Нэвтрэх, гарах хаалт (Swing barrier gate) 3н төхөөрөмжөөс бүрдсэн, орох гарах 2 урсгалтай байна. Төхөөрөмж нь акрил шилэн хаалттай хаалттай (swing) байна. Хурууны хээ болон картаар нэвтрэнэ. Гар болон автомат горимоор ажиллах боломжтой байх ба дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:
  - а. Нэвтрэх хаалтны ком – 1ш
  - б. Уншигч төхөөрөмж (хуруу, карт) – 4ш
  - в. Шаардлагатай програм хангамж
  - г. Нэвтрэх эрхийн карт 200ш
  - д. Ослын үед ашиглах аваарын товчлуур.

### 3. Нэвтрэх, гарах хаалтын шаардлагатай техникийн үзүүлэлт:

№	Тоног төхөөрөмжийн жагсаалт	Зураг	Техникийн үзүүлэлт, тайлбар	Тоо
1	Нэвтрэх хаалтны ком		<ul style="list-style-type: none"> <li>• Хэмжээ: 1500*150*980mm</li> <li>• Хүчдэл: AC220V,50HZ</li> <li>• Мотор: Servo brushles motor</li> <li>• Моторын чадал: 120W</li> <li>• Нээгдэх хаагдах хурд: 0.2 s - 1 s</li> <li>• Урсгалын өргөн: 700mm</li> <li>• Swing хаалтны урт: 350mm</li> <li>• Swing хаалтны эргэх өнцөг: 180°</li> <li>• Ажиллах үеийн дуу чимээ: ≤65db</li> <li>• Орчины температур: -25~70°C</li> <li>• Харьцангуй чийгшил: ≤90%</li> <li>• Оролтын интерфэйс: Хуурай контакт эсвэл 12V-ын сигнал</li> <li>• Холболтын интерфэйс: RS485 electrical standard</li> <li>• Ажиллах орчин: дотор</li> <li>• Туршигдсан тоо: 3 сая удаа</li> <li>• Удирдлагын контроллер: IP-д суурилсан биометрийн стандарт хандалтын контроллер</li> <li>• Нэвтрэх карт: 200 ширхэг</li> <li>• Баталгаат хугацаа: 12 сар ба түүнээс дээш</li> </ul> <p>Дээр дурдсан үзүүлэлтээс багагүй</p>	1
2	Уншигч төхөөрөмж (хуруу, карт)		<ul style="list-style-type: none"> <li>• Ажиллах температур: -10°C~45°C</li> <li>• Ажиллах чийгшил: 20~90%</li> <li>• Хэмжээ: 121.3x77.3x38mm</li> <li>• Алгоритм: ZKFinger v10.0</li> <li>• Ажиллах хүчдэл: 12V DC</li> <li>• Ажиллах гүйдэл хамгийн ихдээ: 140mA</li> <li>• Ажиллах гүйдэл хэвийн горимдоо: 0.72W</li> <li>• Картны давтамж: 125KHz</li> <li>• Холболт: RS485</li> <li>• Хурууны болон хээ болон карт уншигч нь нэвтрэх гарах хаалтан дээрээ суурилагдсан байна.</li> <li>• Баталгаат хугацаа: 12 сар ба түүнээс дээш</li> </ul> <p>Дээр дурдсан үзүүлэлтээс багагүй</p>	4
3	Програм хангамж	ZKAccess 3.5 ба түүнтэй дүйцэхүйц		1

4. **Бараа хүргэх, суурилуулах газар:** Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар



Тав. МАЯГТУУД

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |       |  |
|---|-------|--|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.   |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>1</b> жил байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>14</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах</b>          | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- Шалгах болон турших (ГЕН – 1)** а. Нийлүүлэгч нь бараа хүргэж, суурилуултыг хийж дуусгасны дараа, шаардлагатай 20-30 удаагийн туршилтыг хийж гүйцэтгэн захиалагчид хүлээлгэн өгнө.
- Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** а. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- Баталгаат засвар (ГЕН-5)** а. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Баталгаат засварын хугацаанд үйлдвэрийн эвдрэл гэмтлийг, үнэ төлбөргүй шуурхай засварлана.
- 4. Төлбөр (ГЕН – 7)** а. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)** а. Алданги оногдуулах хувь: **0.5**  
b. Алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна

## Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>1</sup>

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).  
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*